



Нийгмийн сайн сайхны төлөө “Гал голомт” үндэсний хөдөлгөөнийг 1997 оны 02-р сарын 18 ны өдөр нийгмийн зүтгэлтэн, нэртэй бизнесмен, эрдэмтэн дипломатч, эмч багш, хуульч, эдийн засагч, сэтгүүлч зэрэг төрөл бүрийн мэрэгжлийн эмэгтэйчүүд санаачлан байгуулсан бөгөөд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн иргэдийн, ашгийн төлөө бус, улс төрийн намд харъяалалгүй, биеэ даасан, төрийн бус байгууллага юм.

Эрхэм зорилго нь:

“Гал Голомт” “Үндэсний Хөдөлгөөн нь эх орондоо хүмүүнлэг иргэний нийгэм цогцлуулахад нийгмийн бичил орчин-гэр бүлийг хөгжүүлэн, бэхжүүлэх үйлсэд төр засаг, хүн арддаа туслах явдал юм.

Зорилт нь:

Монгол Улсын төрийн бодлогод нийгмийн бүлгүүдийн (хүүхэд, эмэгтэйчүүд, залуучууд, ахмад үеийн) санаа бодлыг тусгуулах, гэр бүлд ёс суртахуун, сэтгэлзүй, дэвшилт уламжлал, нөхөн үржихүй, мэдээлэлийн эрүүл орчин бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах явдал

Зохион байгуулалт нь:

Хөдөлгөөний төв байгууллага нь **зөвлөлдөх төв** юм. Зөвлөлдөх төв нь тэргүүлэгчид, тэргүүн ,дэд тэргүүнүүдийг сонгох ба тэргүүлэгчдийн хурлаас гүйцэтгэх захирлыг томилоно. Хөдөлгөөн гишүүд ба дэмжигчидтэй одоо 200 гаруй гишүүдтэй. Манай хөдөлгөөнд эрэгтэйчүүд бас нэгдсэн байдаг. Гадаад гишүүнээр Япон-Монголын эмэгтэйчүүдийн соёлоор харилцах “Солонго “ нийгэмлэгийн Ерөнхийлөгч хатагтай, профессор М.Фужимото ажилладаг. Хөдөлгөөний салбарыг **хүрээ** гэж нэрлэнэ. Орон нутгийн байршлаар болон ажил, мэрэгжлийн байдлаараа 8 –аас доошгүй хүн нэгдэж хүрээг байгуулж болно. Одоо Дорноговь, Орхон, Дархан-Уул, Дорнод, Завхан, Говь-Алтай, Өмнөговь, Баянхонгор, Говь-Сүмбэр, Баян-Өлгий, Увс аймгуудад салбар хүрээ ажиллаж байна.

**МАНАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТЕХНИКИЙН БОЛОН САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ
ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГУУД:**

Герман-Монголын хамтын ажиллагааны нийгэмлэг, НҮБ-ын Хүн Амын Сан, НҮБ-ын ХДХВ/ДОХ-той Тэмцэх Нэгдсэн Хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн Сан, Глобал Сангийн ДОХ, Сүрьеэгийн төсөл, Соросын Сан

ХАМТРАН АЖИЛЛАДАГ ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД:

ХЗДХЯам, Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам, Хил Хамгаалах Ерөнхий Газар, ЦЕГ, Эрүүл Мэндийн Яам, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Азийн Хөгжлийн Банк, ДОХ-той тэмцэх Үндэсний сан, ХЗДХЯ, ЭМЯ, НХХЯ, ЭМЯ-ны Эрүүл Мэндийн Хөгжлийн Газар, Эрүүл Мэндийн Нэгдлүүд, Аймгийн Эрүүл Мэндийн Газар, УБ Төмөр Зам зэрэг олон улсын болон үндэсний байгууллагууд

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧОО

Нэг. Гэр бүлийн хөгжлийн асуудлаар төрийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэхийг зорьсон хичээл зүтгэл.

Гэр бүлийн талаар явуулах төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг дээшлүүлэх, судлаач эрдэмтэдийн баг бүрдэх, тэдний эрдэм судлалын ажлын үр дүнг нийгэмд хүргэх чиглэлээр нилээд ажил санаачлан ажиллаж ирсэн билээ. “Монголын гэр бүлийн хөгжлийн өнөөгийн байдал” сэдвээр 2002, 2005, 2010 онуудад нийтдээ 4 удаа үндэсний хэмжээний онол практикийн бага хурлууд зохион байгуулж, давхардсан тоогоор 400-аад хүн оролцож, 70 гаруй илтгэл сонсож, төр засагт хандсан зөвлөмжүүд гаргаж өргөн барьсан ба Үндэсний Аюулгүй Байдлын зөвлөлд “Ил захидал” 2-ыг илгээсэн юм.

Хоёр. Өрхийн тэргүүн- хос баганын нэг эрэгтэйчүүдийн мэдлэг, хандлагын төлөвшилд туслахыг зорьсон хичээл зүтгэл

Бид эрчүүдийг дэмжих тэдний гэр бүлийн боловсрол дээшлүүлэхэд туслахыг нэг зорилтоо болгон ажиллаж ирсэн юм. Энэ нь ирээдүйн болон одоо цагийн өрхийн тэргүүнүүд, гэр бүлийн хоёр баганын нэг, тэдний мэдлэг, хандлага, ёс зүй гэр бүлийн аз жаргалын нэг баталгаа гэсэн үнэт зүйлийг эрхэмлэсэний илрэл билээ.

Манай хөдөлгөөн 2000- 2008 онуудад Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Хил хамгаалах Ерөнхий газартай хамтарч хугацаат цэргийн албан хаагчдын дунд гэр бүлийн болон НҮЭМ-ийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэв. Төслийн гол зорилго нь: Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүлийн асуудлаар эрэгтэйчүүдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх замаар гэр бүлийн хөгжил, бэхжилт, нөхөн үржихүйн эрхийг хангахад эрчүүдийн оролцоог дээшлүүлэх, тэднээр дамжуулан мэдээллээс алслагдсан хөдөө орон нутгийн залуучууд, үе тэнгийнхэнд зөв мэдээлэл хүргэх явдал юм.

Гурав. Гэр бүлийн удмын алтан хэлхээний үнэт зүйл-эх, үрсийг энэрэхийг учирласан хичээл зүтгэл

- Соросын сангийн санхүүжилтээр эмэгтэйчүүдийн Бээжингийн Бага Хурлаас дэвшүүлсэн зорилтууд , түүний дотор эхийн эндэгдлийг бууруулах асуудлаар Эрүүл эх - Галын бурхад нэртэй төслийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх
- Японы ядуурлыг бууруулах сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр, Азийн хөгжлийн банкны хэрэгжүүлж байгаа “Эхийн эндэгдлийг бууруулах төсөл” Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт хэрэгжүүлэхэд хамтран оролцох
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр “Эх, нялхаст ээлтэй эмнэлэг” шалгаруулах түвшин боловсруулах төсөл
- Эх нярайн эрүүл мэндийн нэн шаардлагатай болон яаралтай тусламжид ээлтэй орчин сэдэвт ухууллага нөлөөлийн төсөл зэргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд радиогийн 3 цуврал нэвтрүүлэг , Монгол телевизээр 2 удаа ярилцлага хийж холбогдох судалгаанд 70 хүн, 34500 өрхийг хамруулж 600 гаруй хүнд сургалт явуулснаас гадна төрийн үйлчилгээг эх, хүүхдэд хүргэхэд хамтын ажиллагааг сайжруулъя сэдэвт Сонгино-Хайрхан дүүргийн зөвөлгөөн хийсэн.
- Хариу нэхээгүй тус компани ажлын хүрээнд хүний гавъяат их эмч Б.Бүлтэн, Б.Үйлст нар нэн ядуу эмзэг бүлгийн 130 гаруй эмэгтэйчүүдэд үзлэг хийж, сургалт явуулж, зөвөлгөө өгснөөс гадна өрх толгойлсон эмэгтэй болон орлого багатай айл өрхийн нийслэлд шилжин суурьшсан 500 гаруй иргэнийг Нийслэлийн бичиг баримттай болгож 1000 гаруй иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр, “Эх нярайн эрүүл мэндийн нэн шаардлагатай болон яаралтай тусламжийн ээлтэй орчин бүрдүүлэхэд оролцогч талуудын хамтын ажиллагааг идэвхижүүлэх нь” сэдэвт ухуулга нөлөөлөлийн сургалтыг нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг мөн Баян-Өлгий, Увс, Өмнөговь, Завхан аймагт амжилттай зохион байгуулж 300 гаруй оролцогчдыг хамруулав. Тус сургалтаар эх нярайн эрүүл мэндэд ээлтэй орчин бүрдүүлэхэд аймаг, сум, дүүргийн түвшинд тулгамдаж буй асуудал, бэрхшээл, шийдэх арга зам гарах гарцын асуудалаар санал солилцож “Зөвлөмж” гаргаж Аймаг, Дүүргийн ИТХ, Засаг дарга нарт болон ЭМЯ-нд хүргүүлэв.

Дөрөв. Гэр бүлд боловсрол олгож, эрүүл орчин бүрдүүлэх нь үндэсн эрхэм дээд эрх ашиг болохыг тайлбарласан хичээл зүтгэл

“Мэдээлэл , хүмүүжлийн эрүүл орчин”, “Гэр бүлд сэтгэлзүйн эрүүл орчин бүрдүүлье”, “Гэр бүлд эрүүл мэндийн эрүүл орчин бүрдүүлье” уулзалт ярилцлагыг хэвлэл мэдээлэлийн болон холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж “архидан согтуурах явдалтай тэмцэх бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлье” сэдэвт уриалга гаргаж хэвлэл мэдээлэлээр сурталчилснаас гадна “Бизнесийн эрүүл орчин бүрдүүлье” сэдэвт дугуй ширээний ярилцлага хийж Импортын орчинг эрүүл болгох уриалга гаргав.

“Хүн ам ба хөгжлийн сургалт сурталчилгаа” сэдэвт үндэсний семинарыг ЭМНХЯ, НҮБХАС-тай хамтран зохион байгуулж аймгуудын Засаг даргын орлогч нар, ТББ-ын 20 төлөөлөгч, төвийн хэвлэл мэдээлэлийн 8 байгууллага нийт 80 хүн оролцов.

“ДОХ”, БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх төсөл, Ядуурал ба “ХДХВ” хөтөлбөр, “ДОХ-той тэмцэх үндэсний сан”-гийн санхүүжилтээр Сүлжмэлийн “Сүлжээ” үйлдвэрийн ажилчдын дунд “Эрүүл мэнд” сэдэвт аян зохион байгуулав.

НҮБ-ын ХАС-ийн санхүүжилтээр Олон улсын ДОХ-той Тэмцэх өдрийг тохиолдуулан “Баярмаа сан” –тай хамтран хотын захын хороолол болох Сонгино-Хайрхан дүүргийн Баянхошуу, Баянзүрх дүүргийн Дарь Эх, Амгалан, Шар хадны техникийн зах, Нарантуул зах, Гачуурт тосгонд ДОХ-оос сэргийлэх талаар машинт ухуулга, Ченжүүд ДОХ-ын эсрэг “өдөрлөг, тэмцээн уралдааныг зохион байгуулж, 11000 гаруй хүнд сурталчилгаа хийв. Мөн түүнчлэн Дорноговь, Орхон, Эрдэнэт хот, Сайн-шанд, Замын –үүд сумдын эмзэг бүлгийн хүн амд сурталчилгаа, гавъяат эмч нарын эрүүл мэндийн үзлэг хийж өрх толгойлсон 800 эмэгтэйг хамруулснаас гадна 360 хүнд ДОХ, БЗХӨ - өөс сэргийлэх сургалт явуулсан ба 72 хүнийг ДОХ, БЗХӨ - нийг оношлох шинжилгээнд хамруулав. Өмнөговь аймгийн Гашуун-Сухайтын боомт нээгдэх үеэр ченж наймаачдын дунд ДОХ, БЗХӨ -нөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгаа хийхээр “Үе тэнгийн сургагч” –аар 23 хүнийг бэлтгэлээ. сурталчилгааны материал тараасан. 200 –гаад хүн оролцов. Хуулийн зөвлөлгөө, эмийн үйлчилгээ, НҮЭМ-ийн болон гэр бүлийн зөвлөлгөө өгч үйлчлэв.

Соросын Сангийн санхүүжилтээр “Гэр Бүл - Гал Голомт” төслийг хэрэгжүүлж 300 гаруй залуучуудад / ихэнх нь хосууд/ гэр бүлийн асуудлаар 16 цагийн сургалт явуулав. Дархан-Уул, Орхон, Өмнөговь, Дорноговь аймгуудын салбар хүрээдэд гэр бүлийн асуудлаар сургалт явуулах сургагч багш бэлтгэх сургалтыг газар дээр нь зохион байгуулж 40 хүнийг оролцуулав.

2004 оны тавдугаар сарын 14 нд нэг ээлжинд 45-50 хүн сургах хүчин чадалтай, сургалтын бүх техник хэрэгслэлээр иж бүрэн хангагдсан, 500 нэгж материал бүхий мэдээлэлийн багцтай төвийг байгуулж нээлтээ хийсэн.

“Гэр бүлийн хөгжил” сэдэвт сургалтын хөтөлбөр боловсруулж . НХХЯ-тай хамтран аймгуудын ЗДТГ-ын Стратеги төлөвлөлтийн хэлтсийн дарга нарын 3 хоногийн сургалтанд 30 хүн, нийслэлийн хороодын нийгмийн ажилтан 38 хүнд “гэр бүлийн хөгжил” хөтөлбөрийн дагуу 5 өдрийн сургалтыг явуулав.

Германи хамтын ажиллагааны нийгэмлэгийн НҮЭМ-д дэмжлэг үзүүлэх төслийн санхүү, техникийн дэмжлэгтэйгээр “**Мэдлэгийн өртөө**” төслийг УБ, Говь-Алтай, Орхон, Дархан-Уул, Дорноговь, Увс, Баян-Өлгий аймгуудын залуучууд, оюутнууд, цэргүүд, цагдаа, ахлах ангийн сурагчдын БЗДХ, ХДХВ/ДОХ-оос сэргийлэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж, мэдээлэлээр хангах зорилгоор Улаанбаатарт 35, 4 аймагт нийт 60 сургагч багш бэлтгэж давтан сургалтанд 30

хүнийг хамруулж сургалт явуулах бэлтгэгдсэн баг 6 аймагт бүрдлээ. “Мэдлэгийн өртөө” төслийг Салбар бүх хүрээдэд хэрэгжүүлж нийт 2700 хүнд НҮЭМ-ийн болон, БЗДХ, ХДХВ/ДОХ-оос сэргийлэх анхан шатны мэдлэг олгож 8000 орчим залуучуудыг сургалтанд хамрууллаа.

Хөдөлгөөний дэд тэргүүн Ж.Оюунгэрэлийн санаачлагаар “Монголын гал голомт” сониныг үүсгэн байгуулж сониныг мэдээлэл, сурталчилгаа, сургалтын зориулалтаар 13 дугаарыг 5000 гаруй хувь хэвлэн гаргаж, олны хүртээл болгосон. “Манлай гэр бүл” шалгаруулах ажлыг тусгай болзлын дагуу явуулж 4 аймаг, 6 дүүрэгт 30 гаруй гэр бүлийг шалгаруулан тулган цомоор шагнаж ажил амьдралын туршлагыг нь сурталчлаж байна.

“Монгол үндэстний оюунлаг ирээдүйн төлөө” баримтат киног ТВ5 телевизтэй хамтран бүтээж, “Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” судалгааг НҮБХАС, НХХЯ-ны дэмжлэгтэйгээр нийслэл, 4 аймгийн 1000 гэр бүл хамруулан хийж судалгааны материалыг ном болгон хэвлүүлсэн. “Мэдэхэд илүүдэхгүй” гал голомтын танилцуулга, тайлбарт зурагт хуанли, “Цахим хичээл”, видео сургалтын 40 минутын кино, “Эрчүүдийн өврийн дэвтэр” “гэр бүл гал голомт” төслийн тайлан тус тус хэвлүүлж тараав. НҮБ-ын ХАС-гийн дэмжлэгтэйгээр “Дэлхийн хүн амын байдал-1998 он” номыг англи хэлнээс орчуулж 2000ш хэвлүүлэв.

ДОХ-той Тэмцэх Үндэсний Сангийн дэмжлэгтэйгээр “Нээлттэй хаалга” төслийг Замын-Үүдэд хэрэгжүүлж байна.(2010-2013 он) Хөдөлгөөнт хүн амд ДОХ-оос сэргийлэх мэдлэг олгож, , аливаа эрсдлээс хамгаалах зан үйл ,зөв хандлагыг төлөвшүүлэх зорилттой юм. Суудлын галт тэргээр зорчигчдод сурталчилгаа хийх, хилийн орчимд машины үйлчилгээ болон ачаа тээш зөөвөрлөгчид , ачигчид, ахлах ангийн сурагчид өсвөр үеийнхэнийг зорилтот бүлгээ болгон авч төрөл бүрийн сэдэвт ажлууд зохиож байна.

Монгол төрийн бат тулгуур, монгол хүний хөгжлийн бичил орчин, монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын нэг баталгаа, байгаль дэлхийд ээлтэй нүүдэлчний соёлын үнэт өв монгол гэр бүл үүрд оршин, хөгжин дэгжихийн хийморьтой, аз жаргалтай, сэтгэл амгалан, бат түвшин гурван цагийн хэлхээ байлгахын төлөө бүх нийтээр хамтран ажиллахыг уриалан дуудаж байна.

Манай хаяг: СБД 1-р хороо Монгодын Улаан загалмайн нийгэмлэг /МУЗН/-ийн байр 4 давхарт,

Утас: 11-304786, 99139090